

5

МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН ГАЗАР ЭДЭЛБЭРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ

Ц. Цэвээн

Монгол орон нь Төв Азийн өндөрлөгт Баруун тал нь Мааньт уул умард өргөргийн 48°53', дорнод уртрагийн 87°44', зүүн зах нь Модтой хамар умард өргөргийн 46°33', дорнод уртрагийн 119°56', хойд цэг нь Монгол шарын даваа умард өргөргийн 52°09', дорнод уртрагийн 98°57', урд тал нь Орвог гашууны Бор толгой умард өргөргийн 41°35'; дорнод уртрагийн 109°00'-д оршдог.

Далай тэнгисээс алслагдсан мөн өндөр уул нуруудаар хүрээлэгдсэн чийглэг агаарын урсгалыг хаадгаас хур тунадас бага, улиралуудад их ялгаатай унадаг, жилийн дөрвөн улиралтай. Энэ нь эх газрын эрс тэс уур амьсгалын үлэмж тохиромжгүй горимыг нөхцөлдүүлж буй болгодог байна.

Манай гаригийн 59 тэрбум гаруй га гадаргуугийн 29.2 хувь нь хуурай газар буюу 13.4 тэрбум га бөгөөд түүний 29 хувь буюу 4.5 тэрбум га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар юм. Энэ эдэлбэр газрыг тариалан, байгалийн хадлан, мөн малын бэлчээрийн хэлбэрээр ашиглаж байна.

Манай орны хувьд дэлхийн эдэлбэр газрын фондын 1.2 хувь хөдөө аж ахуйн эдэлбэр газрын 3 хувь, бэлчээрийн 5 хувь оногддог нь тийм ч бага хэмжээ биш. Энэ газар нутгаа зориулалтаар нь ангилж үзвэл хөдөө аж ахуйн хэрэгцээнд ашиглаж болох нийт талбай 89%, ойн талбай 9.6%, усны эзлэх талбай 0.9%, хөдөө аж ахуйд ашиглах боломжгүй газар 0.5% байна. Үүнээс үзвэл манай улсын нутгийн 9/10-д хөдөө аж ахуйг хөгжүүлэх болоцоотой.

Монгол нутаг эх газарт оршдог тул далайн төвшнөөс дээш дунджаар 1580 м өргөгдсөн байдаг ба нам газар нь Дорнод аймгийн нутаг дахь Хөх нуурын хотгор далайн төвшинөөс дээш 560 м хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн нурууны Хүйтэн (Найрамдал оргил) уул 4374 м байдаг.

Манай орны газар нутгийг далайн түвшинээс дээш орших байдлыг хувиар авч үзвэл:

1000 хүртэлх метрт	15.3%
1001-1500 метрт	40%
1501-2000 метрт	19.9%
2001-3000 метрт	22.4%
3001-4000 метрт	2.4%
4001-ээс дээш метрт	0.02%

тус тус оршиж байдаг. Далайн төвшинээс дээш ойролцоогоор 3000 метр өндөрт хүртлэх талбайд мал аж ахуй эрхлэн явуулж болох боловч малын төрөл тус бүрт харилцан адилгүй тухайлбал сарлагт өндөр, тэмээнд нам дор газар үхэр, адуу, ямаа дундын бүслүүрт хонь аль ч газар байж, ашиг шимээ өгч нөхөн үржихүйг хэвийн ханган явуулах чадвартай.

Манай орны газар нутгийн зонхилох хэсгийг малын бэлчээрээр ашиглахад нэн тохиромжтой нийт 120 сая гаруй га талбайтай бөгөөд байгаль, газар зүйн янз бүрийн бүсүүдэд харилцан адилгүй хэмжээтэй байршиж байдаг.

Тухайлбал нийт бэлчээрийн 4.6% өндөр уулын, 22.9% ойт хээрийн 28.3% хээрийн, 16.2% говийн, 28% нь Их нуурын хотгор болон говийн алтайн бүсэд байршдагийг судалгаагаар тогтоожээ.

Бэлчээрийн талбай тодорхой орон зайд буюу бүс нутагт ямар хэмжээтэй байршиж буй нь түүний тоон утгыг илэрхийлдэг бол ургамлын ургалт, боловсролт, хагдралт, болон нэгж талбайн ургацын хэмжээ, түүний бүтэц, шимт байдал зэрэг нь чанарын талыг илтгэн харуулдаг.

Бэлчээрийн ургац, болон малын ашиг шимийн гарцад нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг нь цаг уур юм.

Монгол оронд өвлөөс хаврын улиралд шилжих температурын шилжилт нь тус орны хойт хэсэгт дөрөвдүгээр сарын сүүлийн хагаст, өмнөт хэсэгт мөн сарын эхээр болдог.

Манай орны умард чигийн нутгаар есдүгээр сарын дундуур өмнө зүгийн нутагт аравдугаар сарын эхээр ерөнхийдөө сэрүүсч ургамлын ургалт зогсон улмаар хагдардаг.

Хаврын цагт дулааны горим туйлын тогтворгүй дөрөв, тавдугаар саруудад хүйтрэлт, дулааралт нилээд их учраас температурын хэлбэлзэл эрс их юм. Жилийн температурын агууриг 90°C давхад хүрдэг нь (зуны халуун 40°C буюу дээш, өвлийн хүйтэн -50°C буюу доош) эх газрын уур амьсгалын шинж юм. Иймээс хоногийн дулаан хүйтний хэлбэлзэл их тухайлбал 25°C-ээс -20°C-д хүрэх явдал цөөнгүй тохиолддог. Иймд тэнгэрийн байдал маш түргэн өөрчлөгдөх нь аль ч улиралд тохиолдож болно. Жилийн дундаж температур тус орны ихэнхи хэсэгт 0°C-ээс доош харин өмнөт талын ялимгүй хэсэгт нэмэх тэмдэгтэй. Энэ нь манай оронд мөнх цэвдэг умарт өргөрөгийн 47° хүртэл урагш түрсэн байдагтай холбоотой. Иймд умарт зүгийн ихэнхи нутагт улирлын цэвдэг өргөн тархмал, чийглэг ихтэй ул хөрс хавар зуны цагт аажим гэсдэг тул хөрсний дулааны тохиромжгүй горим бүрдэж ийм газраар ургадаг нугын ургамлын хөгжил дорой болохын үндэс болдог.

Нутгийн хойт хэсгийн жилийн дундаж хур тунадас 280-350 мм, өмнө зүгийн нутагт 80-120 мм-с хэтэрдэггүй.

Дээрх байдлаас улбаалан үзэхүй байгалийн нөхцөл нь дотроо бас бие биедээ харилцан нөлөөлөх хэсгүүдэс бүрдэнэ. Үүнд: газар (түүний гадаргуу, ус, ургамал) нөгөөх нь уур амьсгал (халуун, хүйтэн, салхи, хур тунадас) нь хоорондоо хамааралтайгаас гадна бэлчээр, нүүдлийн мал аж ахуйг эрхлэхэд гол нөлөө үзүүлдэг хүчин зүйлүүдийн хамгийн чухал нь болдог.

Монгол орны бэлчээрт 580 төрлийн 2270 гаруй зүйлийн дээд ургамал тэрчлэн (хаг, мөөг, замаг г.м) доод ургамлууд ургадаг бөгөөд эдгээрээс 600 гаруй зүйл нь малын тэжээлийн ач холбогдолтой. Эдгээр бэлчээрийн нийт ургамлын нөмрөг нь дэлхийн бусад орнуудаар барахгүй хил залгаа орших орнуудынхаас гойд ялгаатай.

Түүгээр ч зогсохгүй өөрийн орны доторхи бэлчээрийн ургамлын бүтэц төрөл зүйл нь газрын гадаргын өндөр нам, хөрсний бүтэц, улирлаар унах хур тунадасны хэмжээ, халуун хүйтний температур ялгаатай зэргийн улмаас бэлчээрийн нэгж талбайн ургац өмнө зүгээс умар зүг рүү өтгөрч хэмжээ нь нэмэгдэх боловч ургацын нэгж хэмжээн дэх шимт чанар буурдаг. Харин хойноос урагш болох тусам бэлчээрийн нэгж талбай дахь ургац сийрэгжин хэмжээ нь буурах боловч ургацын нэгж хэмжээн дахь шимт чанар өсдөг өвөрмөц зүй тогтолтой.

Хээрийн бүсээс хойшхи нутгийн бэлчээрийн ургац 8-9 сарын эхэнд, өмнө зүгийн бүсэд 9 дүгээр сарын сүүлчээр дээд хэмжээндээ хүрч үүнээс намарт 73-80, өвөл 48-59, хаварт 47-55 хувь нь хагд хэлбэрээр хадгалагдан үлддэг. Ийм ургац бүхий бэлчээрийн талбайн 42 хувийг зун, намар, 58 хувийг өвөл, хавар ашиглаж байна.

Иймээс байгаль, эдийн засгийн аль ч бүсэд бэлчээрийн эдэлбэрт газар нь жилийн бүхий л хугацааны турш мал аж ахуйг хөтлөн явуулах нөхцөл болдог бөгөөд бэлчээр нүүдлийн мал аж ахуйг түгээмэл эрхэлж буй өнөөгийн байдалд зүй ёсны юм.

Тухайн газар нутгийнхаа онцлогт зохицуулан малаа маллахдаа өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нутгийг буй болгож бэлчээрийг дахин давтахгүйгээр сэлгээ хийдэг улирлын ай зүйд тохирсон экологийн зохистой нутгийг манай малчид олон мянган жилийн турш үе үеийг өртөөлөн дамжуулсан ажиглалт, туршлага дээр үндэслэн бүрдүүлсэн нь чухамдаа өмнөх үеэс бидэнд өвлөгдөн ирсэн оюуны болон материалын олон үнэт баялгийн нэг бөгөөд дэлхийн бэлчээрийн мал маллагааны их санд монголчуудын оруулсан зохих хувь нэмэр гэж үзэх үндэстэй.

Бэлчээр нүүдлийн мал аж ахуйг эрхэлж буй өнөөгийн нөхцөлд малд ашиг шим их буй болгож авч ашиглах явдал нь юуны өмнө бүх төрлийн малд тарга хүч авахуулах ажлаас эхлэлтэй. Малынхаа таргыг өвөл хаврын улиралд хамгийн багаар алдагдуулж дараа үеийн ногоотой залгуулан урьдах тарга дээр нэмж тарга хүч авахуулан хур тарга бүрдүүлэх явдал малчин бүрийн эрмэлзэл, мэрийлт байдаг боловч тэдний арга ажиллагаа, хувийн идэвхи туршлагатай холбоотойгоор нэг ижил нутагт ч үр дүн өөр өөр байдаг. Малд их тарга хүч авахуулах нь малаас арвин их ашиг шим бүрдүүлж, авч ашиглах суурь нөхцөл болох бөгөөд чухамдаа бэлчээрийн газар эдэлбэрийн эдийн засгийн чухал асуудал юм.

Манай малчдын хувьд аятай нөхцөл бүрдсэн үед бэлчээрийг зөв зохистой ашиглавал жилд 600 мянга гаруй тонн махтай тэнцэх тарга хүчийг урьд байсан амьдын жин дээр үйлдвэрлэх боломжтой бөгөөд өнөөгийн зах зээлийн ханшаар тооцвол 500 шахам тэрбум төгрөгийн нөөц бүрдүүлэх боломжтой.

Үүн дээр бусад ашиг шим болох төл, ноос, ноолуур, хөөвөр, хялгас, бод малын ажлын зүтгэх хүч, уналга өдрүүдийг нэмж тооцвол бүр ч их хэмжээ гарах бөгөөд үүнээс учиглан үзэхүл манай орны бэлчээрийн мал аж ахуй өнөө хир нь эдийн засгийн асар их боломжтойг нотолж байна.

Иймд шинжлэх ухааны үндэслэлтэй тооцож боловсруулсан бодлогоор бэлчээрийн мал аж ахуйг удирдан зохицуулбал үр өгөөж нь өсөн нэмэгдэх үндэслэлтэй.

Манай хөдөө аж ахуй зах зээлийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос мал сүргийг малчдад хувьчилсанаас малчин өрхийн аж ахуй буй болж бие даан үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдэн мал хөрөнгөө захиран зарцуулж зах зээлийн харилцаанд оролцон, бизнес үйл ажиллагаа эрхлэх, тэдний бүтээлч, чөлөөт сэтгэлгээ хөгжих зэрэгт сайн нөлөөтэй байгаа боловч манай оронд бүс нутгийг хөгжүүлэх асуудал боловсрогдоогүй, дэд бүтэц сул хөгжилтэй өргөн уудам нутагт таруун байрлалтай байдаг мал аж ахуй нь ган зудад өртөж түүгээр ч зогсохгүй малын төрөл бүрийн халдварт өвчний гаралт идэвхижсэнээс мал олон тоогоор хорогдох явдал ердийн зүйл болж байна. Учир нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан бие биеэ даасан малчин өрхийн аж ахуй дээрхи байдлын эсрэг шийдвэртэй арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх ямарч боломжгүй байдаг л хамаг гэм нь оршиж байгаа юм.

Мөн хүн амын суурьшил ихтэй, хөдөлмөрийн хуваарь зохих хэмжээгээр нарийссан зах зээлийн харилцаа бусад бүсээс харьцангуй давуу улс орны төвийн хэсэг рүү манай орны зах хязгаар нутгаас малчид нүүдэллэх явдал ихэсч тэр хэмжээгээр уугуул нутаг нь эзэнгүйрэх сөрөг тал гарч байна.

Нөгөөтэйгүүр төвийн бүс нутагт малын тоо хэт олширч улирлаар сэлгэх бэлчээрийн талбай хомсдон ургамал нөхөн сэргэх боломжгүй болсноос, малд тохиромжтой шимт ургамлын ургац муудан улмаар цөлжих аюул зарим нутагт нүүрлэж байна. Ийм байдлыг эдийн засгийн болон эрх зүйн нарийн бодлогоор зохицуулах ёстой боловч бид тийм арга хэмжээг хараахан авч явуулж чадаагүй байгаа нь туйлын харамсалтай зүйл юм.

Хөдөө орон нутагт малыг хувьчилсанаас хойш бэлчээрийн ашиглалтыг нэгэн төвөөс зохицуулдаг байдал үгүй болсон боловч малчид тухайн сум орныхоо бэлчээр нутгийг уламжлалт аргадаа түшиглэн эдэлбэрлэн айлсах, (саахлах, аймаглах)-даа малынхаа төрлөөрөө, хүний хувьд танил тал садан сүлбээгээрээ мөн идээшиж дассан нутаг усаараа холбогдон айлсаж албан бус зохион байгуулалтанд орох явдал аль ч нутагт түгээмэл хэлбэртэй байна. Энэ бүгд нь бэлчээр нүүдлийн мал аж ахуйд эртнээс өнөөг хүртэл уламжлагдаж ирсэн хөдөөгийн "хүй"-тэй уялдаатай.

Үүний үндэсүүдийн нэг нь устай хлбоотой. Өнөөгийн малчин өрхийн аж ахуйнууд усаа бараадан улирлын шинж чанартай хот айлууд үүсч төвлөрөн тэр төвөөс гадагш сүргээрээ бэлчээрлэн эдэлбэрлэдэг. Нэг хот айлын бэлчээрийн хүрээнд дунджаар 5-6 хот айл байрлаж байдаг.

Амьдрал дээр хоёроос дээш малчин өрхөөс хот айл, хэд хэдэн хот айлаас нэг усныхан, хэд хэдэн усныханаас нэг нутгийнхан, хэд хэдэн нутгийнхаас нэг сум бүрдэж байна.

Бидний хийсэн ажиглалт судалгаагаар дунджаар 8-12 нутгаас нэг сум бүрдэж байгаа юм.

Нэг нутгийнхан нь тухайн газар орныхоо нөмөр нөөлөг, хүйтэн сэрүүн, ус ургамлыг улирлын үе шатуудтай нь нарийн мэддэг түүндээ мал сүргээ тохируулан маллаж сурснаас гадна мал сүрэг нь газар нутагтаа дасаж өөр нутгийн бэлчээрт тогтохгүй өөрийн нутгийнхаа бэлчээр лүүгээ гүйдэг болтлоо эзэнэгшсэн байдаг. Мөн тэр нутгийн хүмүүс ч өөр хоорондын зан аашийг нэвтэрхий мэддэг хэнтэй яаж харьцах ажил төрлөө хэрхэн зохицуулах талаар хэл амаа ойлголцдог. Хэнд, хэзээ, юугаар, яаж тус дэм болохоо ч мэддэг жаргал зовлонгоо хуваалцдаг хоорондоо хэний ч оролцоогүйгээр нягтарсан хүмүүсийн нэгдэл буй болсон байдаг байна.

Чухамдаа ийм байдалаас үүдэлтэй, ард түмний дунд "мэдэхгүй нутгийн бурхнаас, мэддэг нутгийн чөтгөр дээр" гэсэн үг гарсан буйзаа. Үүнээс үзвэл манай орны хөдөө дэх нэг нутгийнхан гэдэг нь маш их өргөн хүрээтэй ойлголт бөгөөд дээд төр засаг болон орон нутгийн удирдах байгууллагууд нутаг усныханд тулгуурлан зарим бодлого, үйл ажиллагаа явуулахад үр ашгаа

өгөх нь дамжиггүй.

Иймд бэлчээр нүүдлийн мал аж ахуй зонхилон эрхэлж буй өнөө үед тухайн нутгийн малчин хамт олны хүчинд тулгуурлан "бэлчээр нутаг эзэмшигчдийн холбоо" байгуулан ажиллах нь чухал байна. Ингэснээр:

1. Газар нутаг тодорхой эзэн харгалзагчтай болно.
2. Бэлчээр ашиглалт зохион байгуулалтанд орж улмаар нарийн хуваарьтай ашиглан бэлчээр давтагдахаас сэргийлж чадна.
3. Гадны ямар нэгэн бусармаг зүйл хэрэгжүүлэхэд эсэргүүцэл үзүүлж байгаль орчныг хамгаалахад сайн нөлөөтэй.
4. Малчид зохион байгуулалтанд орж хөдөлмөрөө хорших, улмаар мал аж ахуйн хоршоолол үүсч урьд үеэсээ илүү амжилт олон цааш хөгжих боломжид тустай.
5. Хамтарсан зохион байгуулалтанд орсноор малчид бүрт байдаг давуу талыг нийтийн хүртээл болгох мөн ган зуд тохиолдоход хамтын хүчийг зохион байгуулах боломжтой.

Газар бэлчээрийг оновчтой эдэлбэрлэхэд хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд дээрээс бодлого боловсруулж орон нутгийн удирдлага эдний сайн дурын холбоог бэхжүүлэхэд анхаарахдаа ийм ажлыг захиргаадан удирдах эсвэл урсгалаар сул тавихгүй уян хатан бодлого мөрдөх хэрэгтэй юм.

Ер нь монгол орны мал аж ахуйн үйлдвэрлэл, түүнийг эрхэлдэг малчид зах зээлийн өнөөгийн нөхцөлтэй зохицох бүх боломжийг эрэлхийлж буй бөгөөд цаашид бүс нутгийн хөгжилтийн асуудалтай уялдаж эрчимжсэн болон уламжлалт аж ахуйн хэлбэрүүд зэрэгцэн орших төлөв ажиглагдаж байна.

Дэлхийн аливаа улс орон өөртөө тохиромжтой аж ахуйн салбараар газар нутагаа эдэлбэрлэдэг. Ийм салбар манай орны хувьд бэлчээрийн мал аж ахуй бөгөөд цаашид тогтвортой орших нь гарцаагүй юм. Учир нь:

1. Манай орны газар нутгийн 90 гаруй хувь нь бэлчээрийн талбай эзэлдэг бөгөөд түүнийгээ бүрэн шахуу эдэлбэрлэж байна.
2. Өнөөгийн бэлчээр нүүдлийн эрчимгүй мал аж ахуйг цаашид эрчимжүүлэхэд асар их оюунжсан хөдөлмөрийн урт удаан хугацааны туршид уйгагүй оролдлого, нөр хичээнгүй зүтгэлээр бүтээх тул их хугацаа зарцуулна. Түүнчлэн мал аж ахуйн эрчимжилт нь уламжлалт аж ахуйн суурь дээр бүтээгдэнэ гэдгийг тэмдэглэж байна
3. Монгол орны бүх нутагт мал аж ахуйг нэлэнхүй эрчимжүүлэх боломжгүй. Ийм эд-ийн засаг, материалын болон оюуны чадамж бүрдээгүйн дээр үндэсний үйлдвэрлэл сэргэж чадаагүй байна. Гэвч тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд эрчимжсэн аж ахуй бүрдэхийг үгүйсгэхгүй байна. Манай орны өргөн уудам нутагт мал аж ахуй нь тархай байрлалтай учир бэлчээрийн мал аж ахуй эрчимжсэн аж ахуйнуудтай зохих хэмжээгээр зэрэгцэн хөгжих боломжтой.

Мөн 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлсэн үеэс улс орны төвийн нутгуудад, зах хязгаар нутгийн малчин нүүдэллэн ирж суурьших нь өсөж байгаагаас бэлчээр элдэнгэшиж улмаар хомсдолд орох байдалтай байна. Төвлөрсөн хот, сууринуудтай зах зээл бусад газраас давуу энэ хэсэгт мал аж ахуйд эрчимжилт эхэлж хэрэгжих магадлал өндөр байна. Учир нь дээгүүр хүрээнд мал аж ахуйг эрчимжүүлэх асуудлыг дэвшүүлэн тавьж удирдлагын эрэлхийлэл хийж байгаагаас гадна энэ нутгийн малчид ч ашиг шим өндөртэй (ялангуяа мах, сүү ихтэй) малтай болох эрмэлзлэл өрнөж байна. Чухамдаа энэ нь удирдлага, гүйцэтгэгчдийн хүрээнд хүсэл сонирхол нэгдэж байна гэсэн үг юм. Гэхдээ малыг л эрчимжүүлчихвэл хүсэл биелэх мэт өрөөсгөл ойлголт, сонирхлоор нэгдсэн бүлгүүдэд түгээмэл байгааг манай өнөөгийн нийтийн хэвлэлийн тоймоос ажиглаж болно. Ийм үзэл

баримтлал алдаанд хүргэж болзошгүй учир нь Улаанбаатар хотыг сүүгээр хангаж байсан "Партизан", "Гацуурт"-ын сангийн аж ахуйнууд мөн аймаг хотуудын төвийг сүүгээр хангах зориулалттай 400, 800 үнээний фермүүд нь сүүний чиглэлийн эрчимжсэн үүлдрийн үхэртэй байв.

Гэвч эдгээр аж ахуйнууд, фермүүд алдагдалтай ажиллаж байсан бөгөөд улсын зүгээс тэр алдагдлыг нөхөж байлаа. Эдгээрийг хувьчилсны дараа алдагдал гаарч улмаар дампуурав. Үүний цаад үндэс нь эрчимжсэн үүлдрийг эрчимжүүлээгүй газрын шимээр тэтгэх гэсэн нь амжилт ололгүй мөхөлд хүргэсэн гашуун ч гэсэн үнэн сургамжтай зүйл байлаа.

Иймд мал аж ахуйг эрчимжүүлэхийн тулд газар бэлчээрийн эрчимжилтийг хамтад нь цогцолбороор хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд төрийн зүгээс:

Нэгдүгээрт, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэдийн хүчийг зөв зохион байгуулж өндөр ашиг шимтэй шинэ үүлдэр буй болгох мөн эрчимтэй технологи мал аж ахуйн салбарт хэрэглэх;

Хоёрдугаарт, Газар бэлчээрийн өгөөжийг дээшлүүлэхийн тулд агротехник, биологийн шинжлэх ухааны шинэхэн ололтуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, газар тариалан болон таримал бэлчээр хадлангийн талбайг эрчимжүүлэх;

Гуравдугаарт, Үндэсний үйлдвэрлэлийг богино хугацаанд бодитойгоор сэргээх хэрэгтэй. Хөдөө аж ахуйн эрчимжилт нь хөдөө аж ахуйн түүхий эдийг дахин боловсруулдаг үндэсний үйлдвэрлэлийн сэргэлт, хөгжилтэй холбогдохгүйгээр хэрэгжих ямарч боломжгүй. Энэ бүгдийг төрийн бодлого, зохицуулалтад тусгаж амьдралд хэрэгжүүлэх шаардлагатай байна.